

ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 2 ДУГААР САРЫН МЭДЭЭ

ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААН:

Зарим хүмүүсийг Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулах тухай, 2020 онд ОНХС, АЗС, БОХНСЗ болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр Дорнод аймагт хийгдэх хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл, Олборлох үйлдвэрлэлийн дэд зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай, Коронавирусын дэгдэлтээс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай мэдээлэл, “Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-2”-т нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Ээлжит 14 дүгээр хуралдаан зарлах тухай асуудлуудыг тус тус хэлэлцэн батлав.

БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД:

АЙМГИЙН ИТХ-ЫН БОДЛОГЫН ХОРОО ХУРАЛДАВ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нутгийн удирдлага, өргөдөл, гомдол, хяналт, үнэлгээний бодлогын хорооны хурлаар Баянтүмэн сумын 2-р баг Хоёр мэлхийтийн хил орчмын газар Хятадын мал, тариаланд эзлэгдлээ гэх мэдээллийн дагуу холбогдох байгууллагуудаас мэдээллийг сонсож байна.

Хоёр. ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн төсвийн хөрөнгөөр 2019 онд хийгдсэн “Дорнод аймгийн хэрэглэгчийн үнэлгээний судалгаа хийх, тайлагнах” ажлын хүлээн авах ажлыг зөвлөх үйлчилгээний гэрээ, ажлын даалгаврын дагуу зохион байгуулж, үр дүнг аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн баталсан.

ГУРАВ. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТАЛААР:

ТӨСВИЙН ОРЛОГЫН ТАЛААР:

Орон нутгийн нийторлого 20104.4 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 19795.7 сая төгрөг, үүнээс татварын орлого 3055.1 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 3192.5 сая төгрөгт хүрч 137.4 сая төгрөгөөр давж, татварын бус орлого 9488.3 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 9750.6 сая төгрөгт хүрч 171.3 сая төгрөгөөр давж биеллээ.

Орон нутгийн төсвийн нийт орлого

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөөс /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөндүнгээр/	Өөрчлөлт	
			Тоо	Хувь
002 ОРОН НУТГИЙН ОРЛОГО	20,104,400,800.00	19,795,721,828.50	308,678,971.50	98.46
003 ТАТВАРЫН ОРЛОГО	3,055,124,000.00	3,192,501,296.78	137,377,296.78	104.50
004 Орлогын албан татвар	2,032,753,000.00	2,112,633,332.80	79,880,332.80	103.93
016 Хөрөнгийн албан татвар	148,244,000.00	32,277,749.33	(115,966,250.67)	21.77
021 Бусад татвар, төлбөр, хураамж	899,141,900.00	992,809,961.38	93,668,061.38	110.42
041 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,488,370,200.00	9,750,682,374.80	171,301,674.80	102.76
042 Нийтлэг татварын бус орлого	298,343,600.00	601,190,872.40	10,225,771,800	201.51
049 Хөрөнгийн орлого	0.00	460,000.00	460,000.00	#DIV/0!
056 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	8852545400	8364653500	(487.891.900.00)	
058 Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	8,092,345,500.00	8,092,345,500.00	-	100.0
059 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	760,199,900.00	272,308,000.00	(487,891,900.00)	35.8

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТАЛААР:

Аймгийн төсвийн нийт зарлага 16982.2 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 10669.6 сая төгрөгийн гарсан гүйцэтгэлийг бүрэн санхүүжүүлсэн.

Нийт төсвийн зарлагын

- ✓ Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамжинд 58,5%
- ✓ Тогтмол зардалд 18,3%
- ✓ Бараа үйлчилгээний бусад зардалд 9,8%
- ✓ Хөрөнгийн зардалд 13,4% байна.

Аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгт 1494.7 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 8092.3 сая төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүллээ.

Орон нутгийн төсвийн нийт зарлага

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,982,220,700.00	10,669,600,588.29	(6,312,620,111.71)	62.8
Цалинхөлсболоннэмэгдэлурамшил	7,402,854,600.00	5,815,928,748.08	(1,586,925,851.92)	78.6
Ажиллолгогчооснийгмийндаатгалдтө лөхшимтгэл	980,554,200.00	728,900,156.14	(251,654,043.86)	74.3
Бараа үйлчилгээний бусад зардал	968,809,300.00	572,846,630.00	(395,962,670.00)	59.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	968,809,300.00	572,846,630.00	(395,962,670.00)	59.1
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,274,627,500.00	340,584,041.00	(1,934,043,459.00)	15.0

ЖИЧ: Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн дэлгэрэнгүй мэдээлэлийг Аймгийн ЗДТГ-ын № 15 тоот өрөө, www.dornod.gov.mn вэб сайт, 70583034, 70582372 дугаарын утсаар авч болно

Дөрөв. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс аймгийн Засаг даргын захирамжийн биелэлтэд тогтмол хяналт тавьж, аймгийн Засаг даргын 157 захирамжийн эрх зүйн үндэслэлийг хянан, санал өгч, 5 сумын Засаг даргын 102 захирамж, сумын Засаг даргын Тамгын газрын даргын 21 тушаалын эрх зүйн үндэслэлийг хянан гарсан зөрчил, дутагдалд 3 удаагийн зөвлөмж хүргүүлээд байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж нийт 6 өргөдөл ирүүлснээс 6 өргөдөл гомдлыг шийдвэрлэн холбогдох хариуг иргэдэд өгч ажилласан. Аймгийн Засаг даргад хандан мөнгөн тусламж хүссэн 2 иргэнд 600.000 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн сангийн хөрөнгөөс олгуулах ажлыг зохион байгуулаад байна.

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу хөдөөгийн 4 сумын Засаг даргын Тамгын газар болон төсөвт байгууллагуудын 2019 оны үйл ажиллагаанд хяналт мониторинг хийх ажлын хэсэгт ажиллалаа.

Архивын чиглэлээр:

Аймгийн Архивын тасаг нь Монгол улсын Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх” үндэсний хөтөлбөрийн дөрөвдүгээр үе шат /2017-2020/-нд гүйцэтгэх арга хэмжээний төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 оны Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.Албан хэрэг хөтлөлт, хууль тогтоомж, шийдвэрийн талаар:

Архивын тасагт 2020 оны 2 дугаар сарын 29-ний байдлаар ирсэн 8 албан бичгийг хүлээн авч бүртгэн, гадагш 5 тодорхойлолт, 7 албан бичиг боловсруулж явуулсан байна. 3 хариутай бичгийг хугацаанд нь хүргүүлж ажилласан.

2.Баримт ашиглалтын талаар:

2 дугаар сард 3 байгууллага, 148 иргэнээс лавлагаа мэдээллийн захиалга хүлээн авч 447 хуулбар, 22 тодорхойлолт, 55 иргэнд 405 оны малын А данс гаргаж нийт 3 136 000 төгрөгийн орлого оруулав. Хадгаламжийн сангаас 44 хөмрөгийн 178 хадгаламжийн нэгжийг гаргаж ашиглан бүртгэж буцаан байрлуулав.

Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн хүсэлтээр тус сургуулийн бага сургуулийн хичээлийн байрны барилгын ажлын зураг төсөл бүхий 1 ХН, “Степ гоулд” ХХК-ны хүсэлтээр 1436-1539 дугаар бүхий 103 ХН ба нийт 2 байгууллагын хүсэлтээр 104 ХН уншлагын танхимаар олгож ашиглуулав.

2020 ий 2 дугаар сард 1-ны өдрөөс 29-ий өдөр 33 өдөр 15 өдөр 18 690 өдөр 18 өдөр 18 өдөр 18 өдөр 33 өдөр 33 өдөр 1 779 600 өдөр 1 өдөр 1 өдөр 51 өдөр 2 921 100 өдөр 1 өдөр 1 өдөр байна.

Шинээр 1 байгууллагын материалыг хүлээн авч эх хувийг бэлтгэн стандартын дагуу хэвлэж өгөв.

3.Нөхөн бүрдүүлэлт

“Чандмань тал” ХХК-ны хийж гүйцэтгэсэн Хэрлэн сумын 10 дугаар багийн нутаг дэвсгэрт баригдсан “Anna Home “ асрамжийн төвийн барилгын ажлын гүйцэтгэл 447 хуудас бүхий 9 ХН-ээр сан хөмрөгөө нөхөн бүрдүүлээ.

4.Цахим хэлбэрт оруулсан баримтын талаар:

2020 онд цахимжуулах төлөвлөгөөг боловсруулж, сар, улирал, өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөн ажиллаж байна.

- Цахим холболт- 40 хадгаламжийн нэгжийн 6574 хуудас баримт
- Хүний нэр-35173
- Агуулга-6969
- Байгууллагын нэр-0
- Газар зүйн нэр-0

Мөн хөмрөг 92 буюу Нэгдсэн эмнэлэгийн 1992 оны 2 хадгаламжийн нэгжийн 357 хуудасыг фотошоп, РТФ файлд хөрвүүлэн Төрийн архивын программд холболтыг хийж 309 агуулгаар, 3378 хүний нэрийн заагчийг тус тус шивж орууллаа.

5.Бусад

Төрийн архивын баримтын бүрэлдэхүүн хөдөлгөөн, тоо бүртгэлтийн тайлан мэдээг гаргаж Архивын Ерөнхий Газарт хүргүүлэв.

Баян-Уул суманд баригдсан ШТС, Дашбалбар суманд баригдсан 100 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга, Хэрлэн сумын 4 дүгээр багт баригдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн хөгжлийн төвийн барилга зэрэгт улсын комиссын бүрэлдэхүүнд орж ажиллаж, зөвлөгөө өгөв.

Хадгаламжийн сангийн цэвэрлэгээ үйлчилгээг 2 дугаар сарын 6, 13,20-ны өдрүүдэд, чийг дулааны хэмжилтийн бүртгэлийг 2 дугаар сарын 7,14,28-ны өдрүүдэд хөтөлж ажилласан.

Тав. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Нэг. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газар

Цаг үеийн нөхцөл байдлын мэдээлэл:

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн яам, Улсын Онцгой комисс, аймгийн Онцгой комисс, Засаг даргын А/111, А/124 дүгээр захирамж, аймгийн Удирдах ажилтны шуурхай хуралдаанаас гарсан чиг үүрэг, цаг үеийн мэдээ мэдээллийг албан хаагчид хүргэж байгууллагын үйл ажиллагаанд мөрдлөгө болгон ажиллаж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/43 дугаар тушаалыг бүрэн хэрэгжүүлэн ажиллав.

Байгууллагын албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, дархлааг дэмжихээр цагааг уулгаж, албан өрөө, бэлтгэл сургуулилтын заалыг ариутган цэвэрлэж байна.

Цагаан сарын баярын өдрүүдэд нийт албан хаагч, ажилчдыг 02 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд хариуцлагатай жижүүрээр томилон ажиллуулсан.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын дарга Ц.Шаравжамц 7 хүний бүрэлдэхүүнтэй Дорнод аймагт хүрэлцэн ирж, аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын дарга Б.Чимэддорж нартай уулзан Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит “Токио олимп 2020” сангийн цом, удирдамж гардуулан өгөв.

Сургалт, семинар:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга О.Баттулга, Спортын тэмцээн, наадам, стандартын бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн О.Баасан, Залуучууд, өсвөр үеийн шигшээ багийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ш.Долгор нар аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагаанд зөвлөн туслах үйл ажиллагааг зохин байгуулав.

**Хоёр. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
Боловсрол, соёл, урлагийн газар**

Цаг үеийн нөхцөл, байдлын талаар:

Засгийн газар, улс, аймгийн Онцгой комисс, аймгийн Засаг даргын шийдвэрээр тогтоосон хорио цээрийн дэглэмийн үед аймгийн ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, сумдын Соёлын төв, мэргэжлийн урлагийн байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавин аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажиллав.

БСШУСЯ-наас зохион байгуулж буй теле хичээлийн хүртээмж, оролцоонд анхаарал хандуулан өдөр бүр хичээлд хамрагдсан сурагчдын дүн мэдээг нэгтгэн холбогдох дээд байгууллагад хуваарийн дагуу мэдээлэв.

Корона вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор “Корона вирусээс урьдчилан сэргийлье”, сар шинийн өдрүүдэд уг халдвар тархахаас сэргийлж “Хайртай хүмүүсээ хамгаалъя” гэсэн телевизийн шторк бэлтгэн олон нийтийн цахим сүлжээ, сошиал орчинд түгээн нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан.

Засгийн газар, Эрүүл мэндийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газраас өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, тогтоол, тушаал, шийдвэрүүдийг танилцуулах, цаашид анхааралдаа авч ажиллах зарим арга хэмжээний талаар сумдын сургууль, цэцэрлэгийн удирдлагуудтай 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр онлайн хурал зохион байгуулав.

Хурлаар сар шинийн өдрүүдэд шинэ төрлийн коронавирусээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хариуцлагатай жижүүр ажиллуулахдаа цахилгаан, дулааны аюулгүй ажиллагааг хангах зэрэг асуудлаар үүрэг чиглэл өгсөн.

Хөрөнгө оруулалт, барилга, байгууламж:

Дорнод аймгийн Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн өргөтгөлийн (бага сургууль) барилгын ажлын явцтай 2 дугаар сарын 14-ний өдөр танилцав.

Барилгын гадна өрлөг, сантехникийн ажил бүрэн хийгдсэн, цахилгаан монтаж болон дотоод заслын ажил хийгдэж байна.

Барилга угсралтын “ДОЦ” ХХК гүйцэтгэгчээр ажиллаж байгаа бөгөөд өнгөрсөн оны 9 дүгээр сард эхэлсэн уг барилгын явц өнөөдрийн байдлаар 60 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байв.

Гурав. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээлэл:

Хүүхэд, гэр бүлийн эрх зөрчигдсөн асуудлаар өргөдөл, гомдол, хүсэлт, хүүхдийн тусламжийн 108 утсаар нийт 7 дуудлага, 2 өргөдлийг хүлээн авч, хуулийн дагуу хамгааллын хариу үйлчилгээг үзүүлж ажилласан бөгөөд шийдвэрлэлт 70 хувьтай байгаа бөгөөд “Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөө” энэ сард нийт 12 иргэн давтамжтай зөвлөгөө үйлчилгээ авсан байна. “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д энэ сард гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 7 хүн, 3 эмэгтэйг 4 хүүхэд 2-10 хоногийн хугацаатай байршуулж, аюулгүй байдалд хяналт тавин эрүүл мэнд, сэтгэлзүй, хууль эрх зүйн болон холбон зуучлах, хамгааллын үйлчилгээг үзүүлэн харьяа хамтарсан багт шилжүүлж, үйлчлүүлэгчтэй ажиллах кейс төлөвлөгөө боловсруулан хариу үйлчилгээ үзүүлсэн. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 2 хүүхэдтэй ганцаарчилсан уулзалт зохион байгуулж сургалтад хамруулахаас гадна бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон 8 настай охины сэтгэл зүйн дүгнэлтийг гаргаж аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч Цагдаагийн газарт хүргүүлсэн.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээр:

Шинэ төрлийн коронавирусийн халдвар болон томуу, томуу төст өвчний үед болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж, улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоосонтой холбогдуулан Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх зөвлөмж чиглэлийг гарган 14 сум, 25 байгууллага аж ахуй нэгжид хүргэж, мэдээллээр хангаж ажилласан. Мөн онцгой нөхцөл байдлын үед “Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги”-ийн ажиллах төлөвлөгөө зураглалыг байгууллагын даргын 2020 оны А/03 дугаар тушаалаар шинэчлэн батлуулж, хуваарийн дагуу сар шинийн баярын өдрүүдэд өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллахаас гадна мэргэжлийн ангийн төлөвлөгөөнд тодотгол хийж, хүн хүч техник хэрэгслийн судалгааг гарган аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Онцгой байдлын газарт хүргүүлсэн. Мөн коронавирусын дэгдэлттэй холбоотой ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоосны улмаас гэртээ хөл хоригдсон хүүхдүүдийг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх талаар байгууллагын эцэг эхийн зөвлөлд “Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөл”-өөс ирүүлсэн зөвлөмжийг хүргүүлсэн. Мөн хүүхэд, иргэдэд сэрэмжлүүлэх зорилгоор бүлэг, бөөгнөрөл их үүсдэг худалдаа үйлчилгээний төвүүд болох “Шүр”, “Экспо”, “Хан Хэрлэн” худалдааны төвүүдэд ажиллаж, 200 гарын авлага, сэрэмжлүүлэг, мэдээллийг иргэдэд хүргэсэн.

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёл урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран телевизүүдээр коронавирусээс урьдчилан сэргийлэх,

хүүхдийг болзошгүй эрсдлээс сэргийлэх чиглэлээр хэвлэлийн бага хуралд оролцож, эцэг эхийн хараа хяналтыг сайжруулан ажиллах талаар санамж сэрэмжлүүлгийг хүргэн ажилласан. Сар шинийн баярын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, улсын болон аймгийн онцгой комиссын шийдвэрийн дагуу “Цахим золголт” уриалгыг орон сууцны нийт 100 өрхөд тараахаас гадна, цахимаар сурталчилж, уриалгыг хүргэсэн.

Шинэ коронавирусийн халдвар болон томуу, томуу төст өвчний үед болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж, улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоосонтой холбогдуулан байгууллагын 0-10 хүртэлх насны хүүхэдтэй албан хаагчдыг богиносгосон цагаар ажиллуулах тухай байгууллагын даргын 2020 оны А/02 дугаар тушаалыг гаргаж, шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж, хүүхдийг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж ажиллаж байна.

Засгийн газрын 2019 оны “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хурдан морины уралдаан зохион байгуулахгүй байх талаарх зөвлөмж чиглэлийг 14 сумын Засаг дарга нарт болон, аймаг, сумдын морин спорт уяачдын холбоонд хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас алслагдсан сумдын хилийн анги болон дугаар салбаруудад алба хааж буй албан хаагчдын ажил, амьдралтай нь танилцаж, шийдэж болох асуудал, санал хүсэлтийг нь сонсох чөлөөт уулзалт хийж, мэдээлэл хүргэх ажлын хүрээнд Баян-Уул сумын 0275 дугаар ангийн 1-7 дугаар салбарууд, 0132 дугаар ангийн зарим салбаруудад сэтгэл зүйч нар ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллан гэр бүл төлөвлөлт сэдвийн хүрээнд хосын харилцаа, гэр бүлд үр хүүхэд орж ирэхэд ямар өөрчлөлт ордог болох мөн зарим зөвшилцөж болох асуудлыг тодруулан ойлгуулж, ярилцах байдлаар сургалт мэдээллийг хүргэн ажилласан.

Залуучуудын хөгжил оролцооны чиглэлээр:

Гэр бүлийн хүчирхийлэл болон зөрчлийн арга хэмжээ авагдан, эрүүлжүүлэх байранд саатуулагдаж буй нийт 54 хүнд амьдрах ухааны сургалт хариуцсан ажилтан, гэр бүлийн хөгжил, хамгааллын албаны нийгмийн ажилтнууд 3 удаагийн зан үйлээ засах сургалт зохион байгуулж, мэдлэг олгосон.

**Дөрөв. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
Нийгмийн даатгалын хэлтэс**

Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлтийн талаар:

2020 оны 02 дугаар сард нийгмийн даатгалын санд 2020 оны 2 дугаар сард 2705901,2 мянган төгрөг төвлөрүүлэхээс 3080077,14 мянган төгрөг төгрөг төвлөрүүлэн төлөвлөгөөг 113,8 хувиар биелүүлж ажиллав.

Нийгмийг даатгалыг сангийн орлого /мянган төгрөг/

д/д	Төрөл	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Тэтгэврийн даатгалын санд	1836917,8	1973384,88	107,4
2	Тэтгэмжийн даатгалын санд	176354,1	216329,1	122,6
3	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс шалтгаалах өвчний даатгалын санд	156386,0	229575,37	146,8
4	Ажилгүйдлийн даатгалын санд	31877,8	48618,92	152,5
5	ЭМД-ын сан	504365,5	612168,87	121,4
	Нийт	2705901,2	3080077,14	113,8

Нийгмийн даатгалын сангийн зарцуулалтын талаар:

Нийгмийн даатгалын сангаас нийт 10006925,6 төгрөгийн зарлага гаргах төлөвлөгөөтэйгөөс тэтгэвэр авагч, даатгуулагчдад 9473007,5 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардал олгож 94,6 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

Д/д	Нийгмийн даатгалын сан	Тэтгэвэр, тэтгэмжийн төрөл	Даатгуулагчдын тоо	Сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж (мян.төг)
1	Тэтгэврийн даатгалын сан	Өндөр нас тэтгэвэр	8637	6432618,2
		Тахир дутуугийн тэтгэвэр	2762	1661311,5
		Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	605	378231,4
		Цэргийн алба хаасны тэтгэвэр	583	718269,8
2	Тэтгэмжийн даатгалын сан	Хөдөлмөрийн чадвар түр алдсан тэтгэмж	238	29551,8
		Жирэмсэн, амаржсаны тэтгэмж	124	126900,9
		Оршуулгийн тэтгэмж	32	32000,0
3	Үйлдвэрлэлийн осол,	Тахир дутуугийн тгэвэр	63	29580,39
		Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	15	6410,17

	мэргэжлийн өвчнөөс шалтгаалах өвчний даатгалын сан			
4	Ажилгүйдлийн даатгалын сан	Тэтгэмж	16	58133,41
		Сургалтын зардал	0	0
	Нийт дүн		13075	9473007,5

2020 оны 02 дүгээр сарын байдлаар 13075 тэтгэвэр авагч, даатгуулагч, иргэдэд 9473007,5 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хуульд заасан хугацаанд нь бүрэн олгож, тэтгэвэр авагч, даатгуулагч иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээг жигд, хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэлээ.

Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагын чиглэлээр:

2020 оны 02 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 566900.7 мянган төгрөг байна. Нийт шимтгэлийн авлагын 87,7 хувь буюу 497457.4 мянган төгрөгийг аж ахуйн нэгж, байгууллагуудын авлага, 12,2 хувь буюу 69443.3 мянган төгрөгийг төсөвт байгууллагууд эзэлж байна. Нийт авлагын 39.8 хувийг 121 ба түүнээс дээш хоногтой хуримтлагдсан авлагын дүн эзэлж байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага

Д/д	Хуримтлагдсан авлагын хоног	Хуримтлагдсан авлагын дүн (мянган төгрөгөөр)
1	0-30	168 320.5
2	31-60	43 594.6
3	61-90	-
4	91-120	87 313.8
5	121-ээс дээш	198228.5

Нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон

2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх өөрчлөлтүүдийн хэрэгжилтийн талаар:

Малчин хувиараа хөдөлмөр эрхлэгчид тэтгэврийн даатгалын шимтгэлээ нэг удаа нөхөн төлөх талаар:

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

Хуулийн үйлчлэлд тэтгэврийн даатгалын шимтгэлээ нөхөн төлөх хүсэлт гаргасан 15-60 настай Монгол Улсын иргэн хамаарах бөгөөд шимтгэл төлөх хугацаанд иргэний суралцсан, хорих ял эдэлсэн, өндөр насны тэтгэвэр авсан хугацаа хамаарахгүй.

Шимтгэлийг хуулийг дагаж мөрдөх үеийн буюу одоогийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 10 хувиар буюу сард 42000 (420000х10 хувь) төгрөгөөр тооцож төлөхөөр байна.

Уг хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын 2019 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан журам, зааврын дагуу аймгийн хэмжээнд 2020 оны 02 дугаар сард 6 иргэний 22,3 сая төгрөгийн шимтгэлийг тэтгэврийн сангийн дансанд төвлөрүүлсэн.

Төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдийн тоогоор 1 жил 6 сар нэмж тооцдог болсон талаар:

Төрүүлсэн болон гурав хүртэл настайд нь үрчлэн авч зургаан нас хүртэл нь хүүхдээ өгсөн эхийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нийт хугацаан дээр төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн тоогоор нэг жил зургаан сарын нэмж тооцно. Хуулийн үйлчлэлд 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойш шинээр тэтгэвэр тогтоолгох эхчүүдэд хамаарах бөгөөд энэ заалт нь зөвхөн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нийт хугацаанд хамаарах ба хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд, малчнаар, мэргэжлийн урлагийн байгууллагад ажилласан, цэргийн албан хаасан зэрэг тусгай нөхцөлийн жилд хамаарахгүй юм.

Аймгийн хэмжээнд 2020 оны 02 дугаар сард нийт 158 иргэнд шинээр тэтгэвэр тогтоосон. Үүнээс:

Өндөр насны тэтгэвэр 118,

(хэвийн- 36, хувь тэнцсэн 10, малчин 13, хүүхдээр 58, хүнд нөхцөл 1)

Тахир дутуугийн тэтгэвэр 37,

Тэжээгч алдсаны тэтгэвэр 3,

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.5-д зааснаар төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн тоогоор 1 жил 6 сарыг ажилласан хугацаанд тооцох заалт хэрэгжиж эхэлснээр энэ сард өндөр насны тэтгэвэр тогтоолгосон нийт иргэдийн 49%-г эзэлж байна.

Хүүхдээ асрах чөлөөтэй байгаа эхийн шимтгэл төлөлт тасрахгүй байх нөхцөл бүрдсэн талаар:

Хүүхдээ 3 нас хүртэл асрах чөлөөтэй байгаа эхийн нийгмийн даатгалын шимтгэлийг дараах байдлаар төлөхөөр зохицуулсан.

Үүнд:

Албан журмын буюу ажил хөдөлмөр эрхэлж байсан эхийн төлөх шимтгэлийг ажил олгогчоос

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх нь үүссэн сайн дурын даатгуулагч эх шимтгэлийн 50 хувийг өөрөө төлсөн нөхцөлд 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас,

Бусад эхийн шимтгэлийн 50 хувийг өөрөө төлсөн нөхцөлд 50 хувийг улсын төсвөөс хариуцан төлнө.

Уг хуулийн үйлчлэлд аймгийн хэмжээнд 253 эхийг хамруулан шимтгэлийн хөнгөлөлт эдлүүлээд байна.

5. Сайн дурын даатгуулагч эхийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг 100 хувиар тооцож олгох талаар:

Хуулийн зохицуулалтын дагуу 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сайн дурын даатгуулагч эхэд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлсөн 12 сарын орлогын дунджаас 70 хувиар боддог байсан бол 100 хувиар тооцон олгож эхэлсэн.

Уг хуулийн үйлчлэлд хамрагдсан 43 даатгуулагч эхэд 26700,0 мянган төгрөг олгосон бөгөөд үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8000,1 мянган төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянан шалгах:

Аймгийн хэмжээнд 2020 оны 01 дүгээр сараас шинээр тогтоогдсон тэтгэвэр авагчдын 85 иргэний тэтгэврийн тогтоолт, олголтыг шалгаж зөрчилтэй 8 иргэний 810,0 мянган төгрөгийг төлүүлэх, 1 иргэнд дутуу олгосон 275,0 мянган төгрөг олгох, 2 иргэний тэтгэврийг зогсоож шийдвэр гаргаад байна.

Ажилгүйдлийн тэтгэмж 2020 оны 02 дугаар сард шинээр авч буй 20 иргэний мэдээллийг шалгаж 2 иргэний ажилласан хугацааг дахин хянаж зөрчлийг арилгасан.

Хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэмж авч байгаа иргэдийн хуудсыг шалган ажиллаж байна. Уг шалгалтаар 58 тэтгэмж авч буй иргэний мэдээллийг тэтгэмж олгохоос өмнө шалгаж 1 иргэний ажилласан хугацааг дахин хянаж олгох шийдвэр гаргав.

Жиримсэн болон амаржсаны тэтгэмж авч байгаа иргэдийн больницийн хуудасыг шалгаж ажиллав.

Уг шалгалтаар 39 эхийн тэтгэмж авч буй иргэний мэдээллийг тэтгэмж олгохоос өмнө шалгасан. Шалгалтаар 2 эхийн цалин буруу сонголтоор тэтгэмж бодсоныг залруулан ажилласан.

Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах:

Байцаагч, ажилтнуудыг мэргэшүүлэх буюу хуулийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх нэг мөр ойлголттой болгох сургалтыг зохион байгуулж нийт байцаагч, ажилтнуудыг хамруулсан.

Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн өөрчлөлтийн талаар сургалтыг 10 ажил олгогч байгууллагын нийт 428 даатгуулагчид зохион байгууллаа.

Орон нутгийн 2 телевизээр дамжуулан 2 удаагийн нэвтрүүлэг бэлтгэж, иргэдийг мэдээллээр ханган хамтран ажилласан

Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс:

Шинэ коронавируст халвар (COVID-19) гарсантай холбогдуулан иргэдийг олноор цуглуулахгүй байх шийдвэр гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс цахимаар 4 удаа хуралдаж, 281 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөр зохицуулалтын асуудлыг шийдвэрлэснээс 40 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалсан, 190 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгасан, 51 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинээр тогтоосон байна.

Цуцлагдсан 40 иргэний 25 нь өндөр насны тэтгэвэр тогтоолсон, 9 нь заалтын хугацаа дууссан, 6 нь эмчлэн эрүүлжсэн иргэд байна.

Тав. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний чиглэлээр:

Ажил хайгч, ажил олоход хүндрэлтэй, их, дээд сургуулийн төгсөгч ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагч зэрэг нийт 15 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө, мэдээлэл өгч, 34 аж ахуй нэгж, байгууллагаас 72 ажлын байрны захиалга өгч улмаар 67 иргэнийг байнгын ажлын байранд зуучласан байна.

Монгол Улсад ажлын байрыг нэмэгдүүлэх SECiM төслийн санхүүжилтээр “Халамжаас хөдөлмөрт” зорилтын хүрээнд залуусын ажил хийх хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх, бусдаас үлгэр дуурайл авах, хөдөлмөрлөх, тулгарч байгаа асуудлаа хэрхэн шийдвэрлэх тухай цуврал теле зохиомжийг орон нутгийн 2 телевизтэй хамтран өдрийн 4 удаагийн давтамжтайгаар олон нийтэд хүргэж байна.

Шинэ ажлын байр:

Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 2 дугаар сарын байдлаар 1242 иргэн бүртгэлтэй байгаагаас тухайн сард 54 иргэн шинээр бүртгэгдсэн

байна. Нийт 67 иргэнийг байнгын ажлын байранд зуучилснаас 59 нь шинэ ажлын байраар хангагдсан.

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах ажлын хүрээнд:

Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулах хүсэлтэй 1 аж ахуй нэгжийн 206 иргэний хүсэлтийг хүлээн авч судлан, орон нутагт хөдөлмөр эрхлүүлэх тухай дэмжих саналыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлээд байна.

Гадаад иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд хяналт тавих ажлын хүрээнд Гадаадын иргэн харьяатын газрын зүүн бүс дэх газартай хамтран ажиллах санамж бичиг байгуулан мэдээлэл харилцан солилцох, хамтарсан хяналт, шалгалтыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр:

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2020 оны 01 дүгээр тогтоолоор баталсан 2019 оны төсвийн гүйцэтгэл, 2020 оны төсвийн хуваарь, төсөл хөтөлбөрт орсон нэмэлт өөрчлөлтүүд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/43, А/45 дугаар тушаал зэргийг судлан танилцаж, 2020 оны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Сумын Засаг дарга нарт Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан төсөл, хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй иргэдийн судалгааг гаргаж ирүүлэх тухай албан бичгийг хүргүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жижиг зээл олгох үйлчилгээ:

Дэлхийн банкны санхүүжилтээр “Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих” жижиг зээлийн санхүүгийн өмнөх сургалтад 86 иргэний хамруулж, 57 иргэнийг төслийг Төрийн банкинд хүргүүлснээс 31 иргэнд 290,0 сая төгрөгийн зээл олгож, 32 байнгын ажлын байр хадгалагдаад байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдээс хугацаа хэтэрсэн болон хуваарийн дагуу төлөгдөх 380,0 сая төгрөгөөс тус санд 113,5 сая төгрөгийн орлого төвлөрч, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв санд 73,6 сая төгрөгийг төвлөрүүлээд байна.

Аймгийн Төрийн аудитын газрын төлөвлөгөөт шалгалтад 2019 оны санхүүгийн тайланг хянуулан зөрчилгүй дүгнэлт авч, санхүүгийн эргэн төлөлтөд хяналт тавин, төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

Нийгмийн халамжийн тэтгэвэр 1802 иргэн хамрагдаж, 310,7 сая төгрөг, асаргааны тэтгэмжид 1344 иргэнд 118,6 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмжид 1189 иргэнд 104,8 сая төгрөг, эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмжид 4948 иргэнд 231,2 сая төгрөг, ахмад настанд олгох тусламж, хөнгөлөлтөд 309 иргэнд 23,1 сая төгрөг, алдар цолтой ахмад настны нэмэгдэл, хөнгөлөлтийг 27 ахмад настанд 4,1 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тусламж, хөнгөлөлтийг 297 иргэнд 17 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Өрхийн мэдээллийн нэгдсэн сан, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ, хүүхдийн мөнгөний талаар:

Тайлант сард хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг 14 сумын 2354 өрхийн 6981 том хүн, 6091 хүүхдэд, нийт 13038 хүнд хүргэж, 160,4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүнсний эрхийн бичгийг үйлчилгээ үзүүлдэг 44 аж ахуй нэгжийн хүнсний дэлгүүртэй хамтран ажиллах гэрээг сунган байгуулсан.

Өрхийн мэдээллийн нэгдсэн санд 75 иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авч бүртгэсэн. Үүнээс өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд хамрагдахыг хүссэн 63 өргөдөл, амьжиргааны түвшингийн тодорхойлолт авахыг хүссэн 12 өргөдөл байна.

Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд хамрагдах 63 өргөдлөөс тухайн сард 33 өргөдөлийг шийдвэрлэсэн.

Амьжиргааны түвшний 409,679 босго шугамаас доогуурт багтсан 12 иргэнд тодорхойлолт олгож, шинээр төрсөн 172 хүүхдийн мэдээллийг төрсний гэрчилгээний хуулбарыг үндэслэн өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэв.

Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд хамрагдаж, өрхийн түвшин нь хараахан тогтоогдоогүй хяналт хийгдэж байгаа 91 өрх байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний чиглэлээр:

Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан холбогдох газруудад хүргүүлээд байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол нийгмийн хамгааллын салбар комиссын 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан ХНХЯ-д хүргүүлсэн.

ХНХЯСайдын 2020 оны А/10 дугаар тушаал, “Хүүхдийн эрхийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай” 01 дүгээр албан даалгаврын хүрээнд аймгийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс”-ын гишүүдэд албан даалгаврыг цахимаар хүргүүлэн 7 эцэг эх, асран хамгаалагч нарт утсаар мэдээлэл өгсөн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас эмхтгэн гаргаж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэргүүн туршлага” номонд оруулах 2 иргэний материалыг цахим болон цаасаар хүргүүлээд байна.

**Зургаа. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
Эрүүл мэндийн газар:**

Үзлэг, оношилгооны талаар:

Аймгийн Засаг даргын 2020 оны А/38 дугаар захирамжийн дагуу Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд хүүхдийг эмнэлгийн орчноос халдвар авахаас сэргийлж, дуудлагын утас ажиллуулах, яаралтай тусламжийн эмч, жолооч, авто машины тоог нэмэгдүүлэн 0-1 насны хүүхдийн амбулаторийн үзлэгийг гэрийн эргэлтэд шилжүүлсэнтэй холбогдуулан 2020 оны 1 дүгээр сарын 27-оос 2 дугаар сарын 21-нийг хүртэлх хугацаанд нийт 3428 хүүхдэд гэрээр тусламж үйлчилгээ үзүүлсэн.

“Хором бүрээ анхааръя” унаж, бэртэхээс сэргийлэх” аян

“Бага насны хүүхдийг орноос унаж бэртэхээс сэргийлье”, “Халтиргаа, гулгаанаас сэргийлье”, “Унаж бэртэхээс сэргийлэх алхамууд”, “Гэр, орон сууцанд хүүхдийн аюулгүй байдлыг хангая”, “Ахмад настай хүмүүс ясны бэртлээс хэрхэн сэргийлэх вэ?”, “Явганаас унаж бэртэхээс сэргийлэх” зөвлөмж бүхий санамж, зурагт хуудас, сурталчилгааны материалыг боловсруулан анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, мэргэжил арга зүйгээр хангасан.

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төв болон өрх сумын эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсаар дамжуулан “Унаж бэртэхээс сэргийлэх алхамууд”, “Бага насны хүүхдийг орноос унаж бэртэхээс сэргийлье”, “Халтиргаа, гулгаанаас сэргийлье”, “Унаж бэртэхээс сэргийлэх алхамууд”, “Гэр, орон сууцанд хүүхдийн аюулгүй байдлыг хангая”, “Зам тээврийн осол гэмтлээс сэргийлэх” зэрэг инфографик, шторк байршуулж, 1685 иргэн үзэж, давхардсан тоогоор 1235 иргэн бусдад хуваалцан, 958 иргэнд таалагдсан байна.

Өрх, сумын эрүүл мэндийн байгууллагын хүлээлгийн танхимын дэлгэцээр “Уналт бэртэлтээс урьдчилан сэргийлж, эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамрагдах”, “Унаж бэртэхээс сэргийлэх алхамууд”, “Ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх”, “Зам тээврийн осол гэмтлээс сэргийлэх”, “Анхны тусламжийг зөв үзүүлэх” талаар 6

төрлийн видео бичлэг, шторк зөвлөмжийг нэвтрүүлж, сурталчилгааны самбараар ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчин бий болгох талаар нийт давхардсан тоогоор 3036 иргэнд сурталчилсан.

“Чойбалсан хөгжил” Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нийт 45 ажилтан алба хаагч нарт “Анхны тусламжийг зөв үзүүлэх”, “Уналт бэртэлтээс урьдчилан сэргийлж, эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамрагдах”, “Унаж бэртэхээс сэргийлэх алхамууд”, “Зам тээврийн осол гэмтлээс сэргийлэх” сэдвийн хүрээнд Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Мэс засал, гэмтлийн их эмчтэй хамтран сургалтыг зохион байгуулж, 4 төрлийн 80 ширхэг гарын авлага түгээсэн.

Орон нутгийн гэрээтэй телевизээр 2 удаагийн 8 давтамжтайгаар ярилцлага мэдээллийг “Эмч ярьж байна” нэвтрүүлгээр Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Мэс засал, гэмтлийн их эмч “Ахуйн болон зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх”, “Уналт бэртэлтээс урьдчилан сэргийлж, эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамрагдах”, “Анхны тусламжийг зөв үзүүлэх талаар аюулгүй орчин бий болгох зэрэг 4 сэдвээр нэвтрүүлсэн.

Дорнод аймгийн Улаан загалмайн хорооны мэргэжилтэнтэй хамтран аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Зүүн бүсийн Ахмад настны асрамж, халамжийн үйлчилгээний төвийн ахмадууд болон ажилтан нарт “Уналт бэртэлтээс урьдчилан сэргийлж, эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамрагдах, “Унаж бэртэхээс сэргийлэх алхамууд” зэрэг хором бүрээ анхааръя аяны талаар сурталчлан 2 төрлийн 50 гарын авлага түгээж, амин дэм, витаминаар хангасан. Матад сумын Эрүүл мэндийн төв нь орон нутагтаа осол гэмтлээс сэргийлэх 1 сарын аяны хүрээнд спорт зааланд унаж, бэртэхээс сэргийлэх талаар иргэд, залуучууд аж ахуй нэгж, төсөвт байгууллагуудын дунд мэдээ мэдээлэл хийж гарын авлага түгээж, “Гар бөмбөгийн тэмцээн”-ийг зохион байгуулж, 3 байр шалгаруулж шагнаж урамшуулсан.

“Ахуйн осол болон аюулгүй орчин бий болгох, уналт бэртэлтээс урьдчилан сэргийлж, хором бүрээ анхааръя” аяны талаар сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд нийт 8 төрлийн 2431 иргэдэд гарын авлага түгээсэн.

Шинэ коронавирусийн халдварын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах чиглэлээр:

Тусгаарлах өрөө, нөөц орны тоо

Эрүүл мэндийн салбарын хүрээнд 22 эрүүл мэндийн байгууллагад 32 тусгаарлах өрөө, 53 нөөц ортойгоор бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Шадар сайдын 2017 оны А/08 дугаар тушаалаар батлагдсан эрсдлийн үнэлгээний аргачлалын дагуу Дорнод аймгийн салбар, хоорондын эрсдлийн үнэлгээг хийж, Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны А/06 дугаар тушаалаар Гамшгаас хамгаалах албаны штабыг 19 хүний бүрэлдэхүүнтэй, штабын ажиллах журам, коронавирусийн халдварын үед Төлөвлөлт, шуурхай хариу арга хэмжээ, Тархварзүй, Эрсдэлийн үеийн харилцаа холбоо, сургалт, сурталчилгаа, Санхүү нөөцийн 4 багийн бүрэлдэхүүнийг томилон ажиллаж байна.

Мөн 2020 оны А/04 дүгээр тушаалаар нөхцөл байдлын үеийн шуурхай удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, цаг алдалгүй зарлан мэдээллийг дамжуулах зорилгоор шуурхай штаб байгуулж, 7058-3355 дугаарын утсанд 24 цагаар шуурхай жижүүрийг томилон ажиллуулж байна.

Аймгийн Онцгой комиссоос 14 сумын онцгой комиссын бүрэлдэхүүнтэй цахимаар цаг үеийн мэдээллээр /COVID19/ холбогдож, мэдээллийг солилцон мэргэжил арга зүйгээр хангасан.

Хилийн Хавирга, Баянхошуу боомтоор орж ирсэн 500 гаруй иргэдээс 10-14 хоногийн дараа утсаар холбогдож, тандалт судалгаа хийхэд ямар нэгэн коронавирусийн болон томуу, томуу төст өвчний шинж тэмдэг илрээгүй байна.

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн мэргэжилтнүүд 2020 оны 2 дугаар сарын 08-аас 22-ны өдрүүдэд нисэх буудлаас Дорнод-Улаанбаатар чиглэлд нийт 126 иргэн, Авто тээврийн төвөөс Дорнод-Улаанбаатар чиглэлд нийт 771 иргэний биеийн халууныг хэмжиж, хяналт, тандалт хийж ажиллаж байна. Мөн хилийн боомтод ариутгал, халдвартгүйтгэл хийх зааврыг хүргүүлсэн.

Шинэ коронавирусийн халдварын үед эрүүл мэндийн болон хилийн мэргэжлийн хяналтын байгууллагуудад шаардлагатай хувийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж, томилолт, шатахууны зардал, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хүүхэд, яаралтай түргэн тусламжийн тасагт нэмэлтээр ажиллах ажилтнуудын илүү цагийн хөлс, эрүүл мэндийн сургалт сурталчилгаа хийхэд зарцуулах шатахууны зардалд аймгийн Засаг даргын нөөцөөс 23,3 сая төгрөгийг шийдвэрлүүлээд бэлэн байдлыг хангаж ажиллаж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр тусламж, үйлчилгээ үзүүлдэг 22 эрүүл мэндийн байгууллагын нийт 642 ажилчдын дархлааг дэмжих зорилгоор амин дэмээр тогмтол хангаж, үдийн цайнд халуун аарц, чацаргана, аньсаар дэмжлэг үзүүлж байна. Бүсийн оношилгоо, эмчилгээний төв ээлжийн ажилтнуудынхаа дархлааг дэмжихээр халуун аарц, чацаргана, шөлтэй халуун хоолоор өдөр тутам үйлчилж байна. Нийт эмнэлгийн ажилтнууддаа Beres drops дархлаа дэмжих бүтээгдэхүүнийг олгосон.

Эрсдлийн харилцаа холбооны багийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу орон нутгийн “Мижиг”, “Дорнод” телевизүүд, Jaran.mn, Агар студиэр дамжуулан хүн

амыг шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх эмч, мэргэжилтнүүдийн зөвлөмж 4, нөхцөл байдлын мэдээлэл 5, видео 3 зэргийг нэвтрүүлсэн.

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газар болон бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн шинэ коронавирусийн халдвараас сэргийлэх 6 төрлийн 993 ширхэг зөвлөмж, зурагт хуудас, брошурыг төрийн болон төрийн бус байгууллагууд, орон сууцны орцонд байршуулсан.

Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн 2020 оны 2 дугаар сар 14-ний өдрийг дуустал Хэрлэн сумын 11 багт байрлах байгууллага, аж ахуй нэгж, иргэдэд шинэ төрлийн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх мэдээлэл, таниулга хийх, эрүүл ахуй, халдваргүйтгэлийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх зорилгоор сургууль, цэцэрлэгийн эмч нарын 22 хүний бүрэлдэхүүнтэй баг томилон ажиллуулсан. 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар давхардсан тоогоор 878 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, худалдаа, үйлчилгээний газруудад 5718 иргэдэд зөвлөгөө өгч, коронавирусээс хэрхэн урьдчилан сэргийлэх зөвлөмж бүхий 4065 ширхэг плакат, хялбаршуулсан гарын авлага, нийт 160 гаруй амны хаалт тараагаад байна.

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй өвчтөн, сахиуруудад коронавирусийн халдвараас сэргийлэх сургалт, сурталчилгааг хөдөлгөөнт хэлбэрээр зохион байгуулж зөвлөмж, санамжуудыг хэвлэн тарааж байна.

Эрүүл мэндийн яамнаас цахим хуудсаар өгч буй цаг үеийн нөхцөл, байдлын мэдээлэл, зөвлөмж, сэрэмжлүүлгийг бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд өөрсдийн цахим хуудсанд давхардсан тоогоор 29 зөвлөмжийг байршуулж, хандалтын тоо 5000 гаруй байна.

Аймгийн төвийн эрүүл мэндийн байгууллагуудад эмнэл зүй болон халдвар хамгааллын хувцас өмсөх, тайлах, ариутгал, халдваргүйтгэл хийх заавар, сорьц цуглуулах, тандалт хийх сургалтыг 9 удаагийн давтамжтайгаар 497 ажилтанд, хамгаалах хувцас өмсөх, тайлах дадлага ажил 6 удаагийн сургалтаар 148 эмч мэргэжилтэн хамрагдсан. Гар угаах, хамгаалах хувцас хэрэгсэл өмсөх, тайлах, тусгаарлан сэргийлэлтийн арга хэмжээний гардан сургалтыг 7 удаа зохион байгуулж, сургалтын үр дүнг шалгалт авч баталгаажуулсан.

**Зургаа. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО
ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН 02 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

2020.03.05

ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:

МАЛ АЖ АХУЙ:

“Улсын хошой аварга малчин өрх”, “Улсын аварга малчин өрх”-үүд тодорсон: Засгийн газрын 338 дугаар тогтоолын дагуу “Улсын хошой аварга малчин өрх”-өөр Матад сумын Буян-Өндөр багийн малчин Цэвээний Цэрэнпагма, Улсын аварга малчин өрх”-өөр Булган сумын Баян-Уул багийн малчин Очирын Жамбалдорж, Баянтүмэн сумын Хотонт багийн малчин Хооламын Энхбаатар Гурванзагал сумын Рашаант багийн малчин Загдын Чинбат Баяндун сумын Яргай багийн малчин Сампилын Дамдиндорж, Дашбалбар сумын Харзат багийн малчин Дамдинсүрэнгийн Дондогжамц Сэргэлэн сумын Ар хоолой багийн малчин Повдоржийн Аминзүрх нар тодорлоо.

“Аймгийн малчин өрх”-үүд тодорсон: Жил бүр хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулан эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажилласан малчид, тариаланчдыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар шалгаруулдаг уламжлалтай.

XVII жарны “Хотол төгс” хэмээх төмөр хулгана жилийн хаврын тэргүүн сарын шинийн нэгэн-Монголын цагаан сарын баярыг тохиолдуулан Аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж 14 сумын 42 малчин **“Аймгийн аварга малчин өрх”**-өөр шалгаруулсан.

Ботгоны урамшууллын талаар: “Тэмээ” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор 2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 14 сумын 363 малчин өрхийн 1126 толгой ботгонд 22,520,000 төгрөгний урамшууллын материал нэгтгэсэн.

Аймгийн аюулгүйн нөөцийн тэжээл: Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 2017 онд аймгийн мал хамгаалах сангийн хөрөнгөөр худалдан авч аймгийн аюулгүйн нөөцөд 3 жил хадгалж байгаа 15,6 тонн хивэгний чанарыг шалгахад зарим хэсгээрээ борооны ус гоожиж норсон, дарагдаж хатуурсан байгаа тул зарж болохоор хивгийг зах зээлд борлуулж, үлдэгдэл хэрэглэх боломжгүй хивгийг актлах санал гаргасан.

ГАЗАР ТАРИАЛАН:

Энэ онд 6 сумын 17 аж ахуйн нэгж, 1 иргэн 24032 га-д улаан буудайн тариалалт хийх төлөвлөгөөтэй байна. Үүнд 3555 тн үрийн шаардагдахаас 2612 тн үрийн нөөцийг 2019 оны ургацаас нөөцөлж дутагдах болон үрийг шинэчлэлд шаардагдах 1173 тн үрийн захиалгыг ХХААХҮ-ийн яаманд хүргүүлсэн.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 3.4.5. “Хүнсний ногоо дэд хөтөлбөрийн хүрээнд Хэрлэн сумын 5-р баг, Баянтүмэн сумдад “Хүлэмжийн аж ахуй байгуулах” ажлын даалгаварын төслийг боловсруулав.

ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Хүнсний бүтээгдэхүүний үнэ: 2020 оны 01 сарын 28-ны өдрөөс 2020 оны 02 дугаар 29-ны өдрийг хүртэл хүнсний 19 нэр төрлийн бүтээгдэхүүний үнийн судалгааг холбогдох газруудаас авч байна.

Хүнсний бүтээгдэхүүний нөөцийн судалгаа: Хүнсний бараа бүтээгдэхүүний үйлдвэр, худалдаан дахь үлдэгдлийн судалгаа, нөөцийн мэдээ болон гамшгийн үеийн 100 хоногийн хүнсний бүтээгдэхүүний судалгааг орон нутгийн хүн амын тоонд харьцуулан гаргаж ХХААХҮ-ийн яаманд хүргүүлсэн.

Хуванцар сав: Хүнсний шингэн бүтээгдэхүүнийг нөөцлөхөд ашиглаж буй гарал үүсэл тодорхойгүй хуванцар савны хэрэглээг бууруулах ажлыг үе шаттай зохион байгуулахад ашиглах суурь судалгааг 14 сумын 4024 өрхийг хамруулан гаргасан.

Хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбоотойгоор хүнсний үйлдвэрлэл эрхлэгчид болон худалдаа хоол үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр нөөцийн судалгаа авч ажилласан.

Хуванцар савны хэрэглээ болон давсны хэрэглээний талаар албан хаагчдад мэдээлэл өгсөн.

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Шинэ корона буюу covid-19 вирус гарсантай холбогдуулан амны хаалт үйлдвэрлэх боломжтой иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг гаргасан.

Арьс, шир, түүхий эдийн үнэ ханшийн мэдээг ХХААХҮ-ийн яаманд долоо хоног бүрийн баасан гарагт хүргүүлэн ажиллаж байна.

Чулуунхороот сумын Сум хөгжүүлэх сангийн программыг суулгаж, мэдээллийг төв серверт дамжуулсан.

МАЛ ЭМНЭЛГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Баянтүмэн сумын 4 багийн Хотонт гэх газар нутаглах малчин Б.Батдуламын суурьт 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдөр 1 үхэрт дуут өвчний шинж тэмдэг илэрсний дагуу дээж авч шинжилгээнд хамруулахад МЭАЦЛ-ийн 20-26 дугаартай шинжилгээний дүнгээр “Дуут хавдар” өвчин оношлогдсон тул сумын Засаг даргын 2020 оны А/17 дугаар захирамжаар тухайн бүс нутагт “Хязгаарлалтын дэглэм” тогтоон 14 хоногийн хугацаанд тэмцэх арга хэмжээг зохион байгуулан ажилласан.

Тухайн өвчний голомтын бүс дэхь 1км доторхи 3 өрхийн 46 үхэрт эрүүл мэндийн үзлэг хийж, дуут хавдар өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд хамруулж, үхсэн малын сэг зэмийг шатааж, булж устган ариутгал халдваргүйтгэл хийж гүйцэтгэсэн.

Хяналт шалгалтын талаар:

Мал эмнэлгийн газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц үйл ажиллагаа MNS 5368:2018 стандарт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, малын шилжилт хөдөлгөөн, мал эмнэлгийн цахим гэрчилгээний хэрэгжилтийг хангуулж, хяналт тавих ажлаар Гурванзагал, Чулуунхороот сумдад Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, дотоод хяналт, шилжилт хөдөлгөөн, эмийн баталгаажуулалт хариуцсан улсын байцаагч Б. Болормаа 2020 оны 02 дугаар сарын 18,19-ний өдрүүдэд ажилласан.

Ариутгал халдваргүйжүүлэлтийн талаар:

Мал эмнэлгийн газрын даргын батласан малын гоц халдварт өвчний болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, гахай, тахиатай өрх, аж ахуй нэгжид ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажлын удирдамжийн хүрээнд аймгийн хэмжээнд 165 өрх, аж ахуй нэгжийн 5614м² талбайд ариутгал халдваргүйтгэл хийж ажилласан.

ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоол, “Хүн амын нутагшил, суурьшлийн хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулж буй Азийн хөгжлийн банкны холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, аймгийн хэмжээний газар эзэмшил, ашиглалтын талаарх мэдээ, тайлан, судалгааг гаргасан.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нутгийн удирдлага, өргөдөл, гомдол, хяналт, үнэлгээний бодлогын хорооны дарга С.Дэлгэрээс ирүүлсэн 2020 оны 3/34 тоот албан бичгийн дагуу Баянтүмэн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Ашид арвижих үндэс” ХХК-ийн эзэмшил газрууд болон тус байгууллагад хамаарал

бүхий этгээдүүдийн эзэмшиж буй газарт хэмжилт, зураглалыг хийж, бодлогын хорооны хуралд танилцуулсан.

Газрын кадастрын мэдээллийн санд 5 иргэн аж ахуйн нэгжийн кадастрын зургийг оруулж өөрчлөлт хийсэн.

Дундын мэдээллийн сангаар дамжуулж 2 иргэн аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг илгээж гэрчилгээ олгож, гэрээ байгуулсан байна.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулах ажлын хэсэгт дэмжлэг үзүүлж шаардлагатай мэдээ материалаар ханган ажиллаж, барилга хот байгуулалтын чиглэлээр хийхээр төлөвлөж буй ажлуудыг танилцуулсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Халхгол сумын Ялалт баг, Буйр нуурын урд эрэгт “Техникийн цогц шийдэл” ХХК-ийн гүйцэтгэсэн 1.2 км урттай “Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтын хүрээнд эрчим хүчээр хангах цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээний ажлыг ашиглалтад хүлээн авсан.

Зүүн бүсийн тулгуур төв Чойбалсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан агаарын болон төмөр замын хэтийн төлөвлөлтийн талаар хэлэлцүүлгийг Иргэний нисэхийн газар, Улаанбаатар төмөр замын Баянтүмэн тасаг, Авто тээврийн төв, Инженерийн шугам сүлжээний хангагч байгууллагуудын төлөөллийг хамруулан зохион байгууллаа.

Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний засвар зураг болон ажлын зураг, засварын ажлын зураг төсвийг хянан баталгаажуулах ажлыг зохион байгуулж ажиллалаа.

“Сүхжин” ХХК-ийн улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж дууссан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд иргэдийн хөгжлийн төвийн барилга угсралтын ажил бүрэн хийгдэж дууссан тул аймгийн Засаг даргын захирамжаар байнгын ашиглалтад оруулах комисс ажиллаж, ашиглалтад хүлээн авсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд иргэдийн төвийн барилга нь 2 блокоос бүрдэх ба А блок нь тэнхлэгээрээ 31 х 13.4 м зоорьтой 4 давхар, Б болк болох спорт заал нь 36 х18 хэмжээтэй зоорьгүй 2 давхар цутгамал төмөр бетон каркасан хийц бүтээцтэй, аяган суурьтай цутгамал төмөр бетон хучилттай, хавтгай болон металл шувуу нуруун сэндвичин дээвэртэй, 2 блок нь хоорондоо хүзүүвчээр холбогдсон барилга юм.

Дашбалбар сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр “Элтрүүд” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Дашбалбар сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг байнгын ашиглалтад хүлээн авах комисс ажиллаж, ашиглалтд оруулсан.

Тус барилга нь Дашбалбар сумын 5 дугаар багт хуучин цэцэрлэгийн хойд талд байршилтай 100 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилга нь цутгамал бетон шугаман суурьтай, даацын тоосгон хийц бүтээцтэй, угсармал төмөр бетон хучилттай, хавтгай дээвэртэй, тэгш өнцөгт хэлбэртэй, тэнхлэгээрээ 19,96 х 12х2 м хэмжээтэй, 2 давхар барилга юм.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

- Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Байгаль орчны яам, ЮНЕСКО-гийн Үндэсний хорооны дэмжлэгтэйгээр Дорнод Монголын хээр талыг Дэлхийн өвд бүртгүүлэх урьдчилсан судалгааг Монголын шувуу хамгаалах төв, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын "Михаил Зукков" сангийнхантай хамтран хийж байна.

Тус бүс нутаг уул уурхайн үйл ажиллагаанд хэр өртсөн, унаган төрхөө хадгалсан эсэхийг найман сарын турш судлах бөгөөд хэрэв унаган төрхөө хадгалсан байвал Дэлхийн өвд бүртгүүлэх боломж бүрдэх юм.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зарласан “Хоггүй цэвэрхэн монгол” аяны хүрээнд 2 сард сар шинийн баяр болохтой холбогдуулан “Уул овоогоо бохирдуулахгүй цэвэрхэн шинэлцгээе!” уриан дор ард иргэдэд байгаль дэлхийдээ хог хаягдал бий болгохгүйгээр уул овоо, гол усаа зөв сүсэглэн дээдлэх зан үйлийг танин мэдүүлсэн 1 минут 28 секундын шторкийг “Агар студи”-тэй хамтран бэлтгэж орон нутгийн 3 телевиз болон байгууллагын пэйж, фэйсбүүк хуудаснуудаар дамжуулан цахим орчинд сурталчиллаа.

Баян-Уул сумын нутаг Бардан уул, Хээр морьтын даваа, Уст ганга, Баяндун сумын нутаг Үлийн ар, Дун уул, Тэмээн уул, Их газар зэрэг газруудаар цас их орсны улмаас өвөлжилт хүндэрч зэрлэг амьтдын идэш тэжээл хомстож байна гэсэн сумдаас ирүүлсэн хүсэлтийн дагуу идэш тэжээл хомс байгаа газруудад зэрлэг амьтдын байршил нутгийг тогтворжуулах, тэдгээрт үзүүлж байгаа аюул, дарамтыг бууруулах, идэш тэжээлийн хомстлыг багасгах зорилгоор 3 тн хужир шүү, 250 боодол өвс тавьж биотехникийн арга хэмжээ авах ажлыг хийж гүйцэтгэлээ.

